

## Үхэшгүй амьтай болох товлосон дэс дараа бий

**“Адам дотор бүгд  
үхдэгчлэн Христ  
дотор бүгд амьд  
болгогдоно. Харин  
тус бүр өөрийн  
дараалалтай  
байна...” (1 Коринт  
15:22-23).**

Дээрх гайхалтай  
зөгнөл хүн  
төрөлхтөний өвөг эцэг  
Адамаас эхэлдэг. Хүн  
бүр Адамаас гаралтай. Тийм учраас Адамын  
үйлдсэн гэмийн шийтгэлд хүн бүр өртдөг бөгөөд  
гарцаагүй үхэхэд хүрдэг. Энэ нь амь нас хэзээ  
нэгэн цагт төгсөхийг хэлээд зогсохгүй, амьдрал  
тэр чигтээ уруудан доройтсоор үхэх явдал юм.  
“Адам дотор бүгд ҮХДЭГ” гэсэн нь тийм учиртай.



Харин Есүс Христ гэм ба үхлийн асуудлыг  
загалмай дээр шийдсэн. Дахин амилахдаа Тэрээр  
шинэ хүн төрөлхтөнийг эхлүүлжээ. Бидний Аврагч  
амьд учраас үхлийн чанадад орших найдлага  
бидэнд бий. Энэ талаар эртний хүмүүс ч мэддэг  
байлаа. Өмнөх хэдэн нийтлэлд бид энэ бүхнийг  
авч үзсэн бол энэ нийтлэлд тэрхүү гайхамшигт  
найдлагын тухай Бичвэрүүдийн өгсөн мэдээллийг  
дэлгэнгүй авч үзэн, тус найдлага юутай бат  
болохыг олж харах болно.




Нарийн хэлэхэд дээрх ишлэл зөвхөн дахин амилахын тухай биш, харин ямар ч муудах хүчинд хөндөгдөхын аргагүй амьтай болох яруу жавхлангийн тухай юм. Тухайлбал: Бүтээгч Эзэн үхлийг үгүй болгохын тулд биднийг дахин амилуулах нь үнэн. Харин дахин үхдэг байх явцанд орж үхэхгүйн тулд бидэнд жинхэнэ Амь буюу “амьд болгогдох” явдал хэрэгтэй. Бидний Их Эзэн бол дан Амилал байгаад зогсохгүй, Тэр бас мөхөшгүй Амь билээ (Иохан 11:25).



Есүс Лазарыг дахин амилуулахдаа Амилал нь болсон. Гэтэл Лазар дахин үхжээ. Ирээдүйд Есүс Лазарыг дахин булшнаас дуудахдаа муудашгүй, мөхөшгүй амь хайрлаж бас Амь нь болно.

Үхлээр төгсөх өнөөгийн хэцүү амьдралыг дээрх ишлэлд ирээдүйн сайхан үхэшгүй амьдралтай эсрэгцүүлж зүйрлэсэн.

“Амьд болгогдох” гэдэг нь “алдар, хүч” дүүрэн бөгөөд хэзээ ч “үл муудах” амьтай болохыг хэлнэ (1 Коринт 15:42-44). Өөрөөр хэлбэл, тэр амьдралд үхлийн уруудах явц явагдахгүй, “ялзралын боолчлол” байхгүй байх болно (Ром 8:20-23).




Үхэл олон мянган жилийн турш ажиллан, хүн бүрийг яалт ч үгүй булш руу чирж ирсэн.



Харин Бүтээгч Эзэний ирээдүйд өгөх Амь биднийг хэзээ ч дуусашгүй хүч чадлаар дүүрэн, яруу алдраар гэрэлтэх амьдралтай болгоно. Эхний амьдралыг тэсч өнгөрүүлсэн бүхэн

хоёрдахь амьдралаар баясан хөөрөх болно. Энэ бол хамаг хүн төрөлхтөнд жинхэнэ сайн мэдээ юм! Өнөөгийн дорой байдлаа хожмын яруу алдрын үндэс болохыг ойлгосон бид өнөөдрийн хэцүү дорой байдалдаа хүртэл баярлаж чадна.

**“Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно...”** Үхэшгүй амьтай болох найдлага нь Адамаас гаралтай хүн бүрт хамаатай нь эндээс ойлгогдож байна. Энэ өгүүлбэрийн эзэн “бүгд”. Хоёр удаа гарсан “бүгд” өгүүлбэрийн нэг л эзнийг хэлнэ. “Христ дотор буй бүгд” гэж хэлээгүйг анхаараарай. “Түүн дотор бүтээгдсэн” ба Түүнтэй хамт нас барсанд тооцогддог хамаг хүн төрөлхтөнийг энд хэлсэн байна (Колоссас 1:16; 2 Коринт 5:14). Адамын эхлүүлсэн хүн төрөлхтөнд багтсан бүх хүн бас Христийн тэргүүлэх шинэ хүн төрөлхтөнд хамрагдах ёстой. Христийн тэргүүлэх хүмүүсийн тоо Адамынхны тоогоос бага байх ёсгүй нь мэдээж.



**“...Харин тус бүр өөрийн дараалалтай байна.”**

Эндээс харахад үхэшгүй амийг бүгд зэрэг биш, харин товлосон дэс дараагаар хүртэх болно. Адамын тэргүүлсэн хүмүүс олон мянган жилийн турш үе үеэрээ хорвоод мэндэлсэн бөгөөд өнөө хүртэл тоо нь бүрдэж дуусаагүй байна. Шинэ хүн төрөлхтөн мөн адил дараа дараалан гарах болно. Гэтэл олон үеэр биш, “амьд болгогдох” нь гуравхан үе шатаар явагдана. “Дараалал” гэж орчуулсан грек үг ер нь цэргийн “журамтай дараалж жагсаасан анги”-ыг хэлнэ.

### Авралын жагсаал

Энэ жагсаалын эхэнд Есүс Христ ганцаараа манлайлна. Паул бичихдээ: “...Христ бол анхны үр жимс” (1 Коринт 15:23). Улмаар, “Христ үхэгсдээс амилуулагдсан тул дахиж хэзээ ч үхэхгүйг бид мэднэ. Үхэл цаашид Түүнийг захирахгүй” (Ром 6:9).

Лазар зэрэг хүмүүс Есүсээс түрүүлж үхлээс амилсан нь үнэн. Гэтэл дахин хэлэхэд, тэд тухайн үед үхэшгүй амьдралтай болоогүй, хэсэг хугацааны дараа амьсгаа дахин хураалаа. Дахиад л үхэлд хүргэх тийм амиллыг дээрх ишлэлд тооцоогүй, үхэшгүй амьдралтай болох тухай нь батлагдаж байна.

Тэр л утгаар Есүс дахин амилсан *анхны хүн* мөн. Тэр л утгаар “бүгд амьд болгогдоно”!




Үхэшгүй амьдралын энэхүү “жагсаал”-ыг удирдаж буй нь Есүс ганцаараа. Тэр бол энэ замыг анх гаргасан “авралын маань ахмад” билээ (Еврей 2:10, АБ “Эхлүүлэгч”). Одоогийн байдлаар “зөвхөн Түүнд л үхэшгүй мөнх буй...” (1 Тимот 6:16). Энэ үгээс харахад өөр хэн ч үхэшгүй амьдралыг хүртэж амжаагүй байна.

Үхэл нэгэнт Есүс Христэд ялагдсан учраас хүн төрөлхтөн ахиад амилж Түүн шиг үхэшгүй амьдралтай болох нь баталгаатай!



Иймд “...дараа нь Түүнийг ирэхэд Христийнхэн амилуулагдана” (1 Коринт 15:23, грек эхэнд үйл үг давтагдаагүй байна). Өөрөөр хэлбэл, хоёрдахь анги нь Христийнх болсон итгэгчдээр бүрдэнэ. Тэд нэг ёсондоо авралын ахмадыг шууд дагах манлай анги. Есүс Их Эзэнийг удахгүй энэ дэлхийд буцаж ирэх тэр үед манлайлагч бид үхэшгүй амьдралыг хүртэх цаг болно.

“Адамын дотор” үхдэг хүний тоо итгэгчдээр барагдахгүй нь мэдээж. Цэрэг нь ахмадын ба манлай ангиараа дуусдаггүй нь мөн ойлгомжтой. Паул үргэлжлүүлэхдээ дурдсан дарааллынхаа гуравдугаар ангийн тухай бичихдээ:



**“Дараа нь бүх удирдлага, эрх мэдэл, хүчийг Тэр хүчингүй болгоод Эцэг Бурханд хаанчлалыг тушаах үед төгсгөл ирнэ. Учир нь бүх дайснаа хөл дороо оруулах хүртэл Тэр хаанчлах ёстой.**

**Эцэст нь хүчингүй болох дайсан бол үхэл мөн... Энэ нь Бурхан бүгдэд бүх юм болохын тулд юм” (1 Коринт 15:24-28).**


Энэ гуравдугаар анги “бүх дайсан” буюу Христийнх болоогүй байсан бүх хүн болон “удирдлага, эрх мэдэл, хүч”-ээр бүрдсэн юм байна. Есүс Аавдаа загалмай дээр үхтлээ дуулгавартай байсан учраас Аав нь Түүнийг “үлэмжийн дээдээр өргөмжилсөн”. Иймээс өвдөгтэй бүхэн Түүний өмнө өвдөг сөгдөн, хэлтэй бүхэн Түүнийг Их Эзэн гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд энэ нь Ертөнцийн Эзэн-Эцэгийг алдаршуулна (Филиппой 2:8-11).

Бүгд нэг ёсондоо Түүний ялалтын парадад оролцох ёстой. Энэ нь Түүнийг хаанчлахдаа бүх дайснаа хөл дороо оруулахын үр дүн байх болно. Есүс их Эзэн бүх дайснуудаа “хөл дороо оруулах”-



ын тухай уншихдаа Их Эзэн дайснуудаа хүртэл хайрладгийг санаарай (Матай 5:44-48)<sup>1</sup>.


Дайснаа дарах хамгийн сайн сайхан арга зам бол дайснаа найз болгох явдал юм. Үнэхээр Бүтээгч Эзэн “газар дээрх эсвэл тэнгэр дэх бүх юмсыг Өөртэйгөө эвлэрүүлэх”-ээр төлөвлөсөн бөгөөд энэ эвлэрэл “загалмайн цус”-ны үндсэн дээр явагдана (Холоссай 1:20).



## ЭВЛЭРҮҮЛЭХ

Итгэгч бид өмнө нь бусдын адил өөрийнхөөрөө явж, Бүтээгч Эзэний дайсан байсан билээ (Ром 5:10). Тийм байхад бид даанч Их Эзэний дээрх үгийг үл ойшоон, бүр араас маань дагах, гуравдахь ангийг бүрдүүлэх хүмүүсийг “үхэшгүй амьдралын жагсаал”-аас хасах нь олонтаа.

1 Их Эзэн Өөрийнхөө хийж чадахгүйг хүнд тушаадаггүй. Иймд Есүс энэ дэлхий дээр байхдаа Мосед өгсөн Хуулиа төгс биелүүлсэн. Израйлийн хаан хуулийг дагах ёстой (2 Самуел 12-г үзнэ үү – Давид хаан хуулийг зөрчсөний улмаас шийтгэл хүртсэн). Есүс хаанчлахдаа хэзээ ч Хуулийг зөрчихгүй. Матай 5-7-д тэмдэглэсэн “Уулан дээрх сургаал”-аараа Есүс ирээдүйн Хаант улсын хуулийг танилцуулжээ. Тэр хууль дайснаа хүртэл хайрлахыг шаарддаг. Иймд Есүс Хаан дайснаа хүртэл хайрлах болно. Хайр хатуу байсан ч үргэлж бусдын сайн сайхныг эрэлхийлдэг юм.




Харин дээрх үг тов тодорхой: “Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно. Харин тус бүр өөрийн дараалалтай байна... Энэ нь Бурхан бүгдэд бүх юм болохын тулд юм” (1 Коринт 15:22-23, 28).

Бүтээгч Эзэний энэ зорилгоо биелэхгүй гэж үү? Биелэлгүй яах вэ! Тэрээр “бүх юмсыг хүслийнхээ зөвлөгөөгөөр үйлддэг” юм (Эфэс 1:11). Хамгийн сүүлд үгүй болох дайсан бол Үхэл. Үхлийг Есүс Их Эзэн аль хэдийнэ ялсан боловч хүчингүй болгох нь дутуу. Үхэл хүчингүй болоход амь амьдралаас өөр юу үлдэх вэ дээ. Тэр үед “хоёр дахь үхэл”-ээр үхсэн хүмүүс хүртэл (Илчлэл 20:11-15) дахиад л амилж харин энэ удаад үхэшгүй амь хүртэх болно. Энэ замаар Есүс Христ Адамын алдсан бүхнийг эргүүлэн аваад зогсохгүй, үүнээс ч хавьгүй илүү их үр дүнд хүрнэ!

Зорьсон бүхэндээ хүрсэн тэр үед Есүс Хаанчлалаа Аавдаа тушаан өгөх болно. Үүнээс харахад, Есүс “мөнхийн мөнхөд” хаанчлахгүй, Түүний хаанчлал тодорхой зорилготой. Тус зорилгондоо хүрэхээр Есүс хаанчлахаа болино. Гэтэл Хаант улсыг Бүтээгч Эцэг авч явах учраас Хаант улс нь хэзээ ч дуусахгүйгээр үргэлжилнэ (“Түүний хаант улс эцэс төгсгөлгүй” Лук 1:33).<sup>2</sup>

2 Жич: АБ “хаант улс” биш, “хаанчлал” гэж орчуулсан тул Христ хэзээ ч хаанчлахаа болихгүй гэж ойлгогдож байна. Грек эх үг нь аль ч утгатай байж болно. Бичвэр дотроо зөрчихгүй учраас “хаант улс” энд зөв.



Хаанчлал Хүүгээс Аавд шилжих тэр үед “төгсгөл ирнэ”. Хаант улс нь нэгэнт төгсгөлгүй учраас “Төгсгөл” гэсэн үг цаг хугацааны эцсийг хэлээгүй нь ойлгомжтой. Төгсгөл гэдэг нь “зорьсон зорилгын биелэл”-ийг хэлнэ. Энэхүү төгсгөл дээр Бүтээгч Эзэний Бичвэрүүдэд илчилсэн төлөвлөгөө нь төгс биелэгдэх болно.

Христийн ялалтын үр дүнд Ертөнцийн Эзэн “бүгдэд бүх юм нь” болох болно! Адамын хувьд Бүтээгч Эзэн нь лав “бүх юм нь” болоогүй байв. Итгэгч бид магтан дуундаа “Та бол миний бүх юм” мэтийн үг дуулдаг боловч үнэндээ яг тийм болж чадаагүй. Итгэгч бидний хувьд Бүтээгч Эзэн чухал боловч Түүний өгсөн бэлэг өнөөгийн амьдралд маань чухал байр суурь эзлэх нь аргагүй. Одоогийн байдлаар Бүтээгч Эзэн зөвхөн Есүс Христийн хувьд Бүх юм нь болсон байна. Гэтэл удалгүй “амьд болгогдох” мөчөөс минь эхлэн Тэрээр бидний хувьд ч гэсэн “бүх юм маань болох” юм. Энэ нь яваандаа бүх дайсны хувьд ч тийм байх болно. “БҮГДЭД бүх юм нь болох”-ыг зорьсон Бүтээгч Эзэн зорьсондоо хүрэх нь зайлшгүй.

### **Израйлын ургацын баярын дүрслэл**

Дээрх ишлэлд Есүс Христийг “анхны үр жимс” гэж нэрлэсэн нь мөн учиртай. Энэ грек үгээр израильчуудад тэмдэглэхээр тушаасан Анхны үр жимсний баярыг нэрлэсэн (Левит 23:9-14, Септуагинта хэмээх грек орчуулга).



Тухайн еврей үг “анхны, эхлэл, дээж, хамгийн сайн, тэргүүн” гэсэн утгатай. Хамаг Бичвэр Христийн тухай учраас «Левит» номд товлосон Их Эзэний долоон баяр ч гэсэн Түүнийг харуулах үлгэр загвар юм (Лук 24:25-27).



Тус баярын эхнийх нь Дээгүүр Өнгөрөх баяр нь хавар, нарийн хэлэхэд Нисан хэмээх иудейн эхний сарын 14-нд тэмдэглэх ёстой. Маргааш нь (Нисан 15-нд) Исгээгүй талхны баяр болдог (Левит 23:4-8). Хаврын гуравдахь баяр болох Анхны үр жимсний баярыг Дээгүүр Өнгөрөх баярын дараах бямба гаригийн маргаашид тэмдэглэх ёстой. Израйльчууд сарны хуанлитай байсан учраас Нисан 14 нь Цагаан сар шиг жил бүр өөр өдөрт тохиолдох учраас Анхны үр жимсний баярт тодорхой огноо байхгүй ч ням гаригт тэмдэглэх ёстой нь тодорхой.<sup>3</sup>

- 3 Фарисайчууд садукайчуудтай баяруудын талаар ч маргалддаг байв. Израйльчуудын тооцоогоор нар жаргахад шинэ өдөр эхэлдэг билээ. Дээгүүр өнгөрөх баярын зоогийг садукайчууд Нисан 14 эхлэхэд (буюу 13-ны нар жаргасны дараа) иддэг байсан учраас хургыг нь 13-ны үдээс хойш нядалдаг байв. Харин фарисайчуудийн уламжлалын дагуу хургыг 14-д нядлаад зоогийг тэр орой буюу Нисан 15-ны эхэнд иддэг. Тэд мөн 15-ны эхэнд Исгээгүй талхны баярыг зэрэг тэмдэглэж, Их Эзэний зааврын дагуу тустай байх ёстой тэр хоёр баярыг нийлүүлдэг байв. Үүнээс дүгнэхэд садукайчуудын зөв болж таарна. Фарисайчууд садукайчуудтай мөн Анхны үр жимсний баярын огноогийн талаар маргалддаг байсан. (Үргэлжлэл бий)



Израильчууд тэр баяраар Бүтээгч Эзэнд арвайн ургацынхаа анхны үр жимс буюу дээж юүжийг (тариа багцалсан боодлыг) өргөн барьдаг байв. Ургац бүхлээрээ Түүнийх бөгөөд Түүний өгсөн бэлэг болохыг тэд энэ баяраар дамжин хүлээн зөвшөөрч, талархлаа илэрхийлж, мөн сайн ургац хураан авах ивээлийг гуйдаг байсан.

**Анхны үр жимс бүхэл бүтэн ургацыг төлөөлдөг бөгөөд ургац арвин хураагдахын баталгаа гэсэн үг.**

---

(Үргэлжлэл) Фарисайчууд Анхны үр жимсний баярыг Нисан 16-д (онцгой Шабат амралтын өдөр болсны маргаашид) тэмдэглэх ёстой гэж үздэг байхад садукайчууд: “үгүй, Бичвэрийн дагуу Нисан 14-ны дараах жирийн шаббат буюу бямба гаригийн маргаашид тэмдэглэнэ” гэж зүтгэдэг байв. Бичвэрийг уншихад бас л садукайчуудын зөв юм шиг.

Гэвч түүхч Флавийн Иосефусын дагуу Есүсийн үеийнхэн энэ маргааны хувьд фарисайчуудыг дагадаг байв. Өнөөг хүртэл иудейчүүд фарисайчуудын уламжлалыг дагаж, хоёр баярыг зэрэг 15-ны эхэнд, харин гуравдахь баярыг 16-нд тэмдэглэдэг (өнөөдөр олон христчин теологич хүртэл фарисайчуудын ойлголтыг дэмждэг). Гэтэл Есүс Өөрийгөө “газрын зүрхэнд гурван өдөр, гурван шөнө байх болно” гэж зөгнөсөн билээ (Матай 12:40). Фарисайчуудын уламжлалд энэ зөгнөл биелэхэд хангалттай цаг байхгүй нь бас л садукайчуудын үзлийг дэмжинэ. Тиймээс Есүс садукайчуудын хургаа нядалсан тэр үед загалмайд нас барсан болж таарна. Тэгвэл Есүс лхагва гаригийн үдээс хойш нас бараад ням гаригийн эхэнд (манайхаар бол бямба гаригт нар жаргасны дараа) дахин амилсан гэсэн үг. Үүнд МЭ 30 оны хуанли хамгийн сайн таарна.



Дээгүүр өнгөрөх баярт нядлуулдаг хурга нь тэр л баярын өдрөөр загалмайд өргөгдсөн Есүсийг билэгддэг (1 Коринт 5:7). Исгээгүй талхны баяр нь Түүний гэм нүглийг зайлуулж гүйцэтгэсний дараа булшлагдсаныг билэгдэнэ (исгэх хөрөнгө гэм нүглийн билэг тэмдэг, 1 Коринт 5:8). Харин Анхны үр жимсний баяр нь Түүний ням гаригт дахин амилсныг билэгддэг гэдгийг дээрх ишлэл заадаг.

**“Өргөл дээж [грек: Анхны үр жимс] ариун бол үлдсэн нь бүхэлдээ мөн тийм”** (Ром 11:16) гэдэг зарчим бий. Энэхүү зарчмын дагуу ургацын дээжийг өргөх нь бүхэл бүтэн ургацыг Бүтээгч Эзэнд зориулж ариутгах утга учиртай. Хүн төрөлтөн бол мөн ургац мэт (Матай 9:36-38). Харин тэрхүү ургацын дээж болсон Есүс тэр ургацыг төлөөлөн байж, Бүтээгч Эзэнд зориулж ариутгасан ажээ.



Анхны үр жимсний баярыг мөн “Ургацын баяр” гэдэг (Египетээс гарсан нь 23:16). Гэтэл ганц биш, нийт гурван ургацын баяр байдаг. Анхны үр жимсний баяраас хойш тавь хоногийн дараа Долоо хоногуудын баяр (грек: “Пентекост”) болдог байв (Левит 23:15-17). Энэ баяраар Бүтээгч Эзэнд улаан буудайн дээжийн гурилаар барьсан хоёр талхыг өргөн барьдаг байв. Энэ ургац нь Христэд итгэгчдийг билэгддэг.





Ертөнцийн Эзэн Христэд итгэгчдийг “**анхны үр жимс** болгон авралын төлөө сонгосон ажээ” (2 Тесалоник 2:13). Анхны үр жимс нь онцгойлон Ертөнцийн Эзэнийх учраас итгэгчид “Христийнхэн” мөн бөгөөд түрүүлж “хураагдах” буюу аврагдах болно.

**“Христ бол анхны үр жимс, дараа нь Түүнийг ирэхэд Христийнхэн амилуулагдана”** (1 Коринт 15:23).

Хэрэв итгэгчид дөнгөж ургацын анхны үр жимс юм бол бүхэл бүтэн ургац араас дагах нь зайлшгүй. Зөвхөн дээжээ хурааж, үлдсэн ургацаа шатаадаг тариаланчин гэж байхгүй.



Ургац хураах баярууд дээр хэлсэнчлэн хоёр баяраар дуусаагүй. Израйльчууд намар буюу ургацын жилийн *эцэст* бусад бүх *ургацыг* хурааж авсныхаа дараа Ургац хураалтын баярыг маш их баяр хөөртэйгээр тэмдэглэдэг байсан (Египетээс гарсан нь 34:22). Энэ нь Бүтээгч Эзэний төлөвлөгөөний эцэст болох хүн төрөлхтөний сүүлчийн ургацыг дүрсэлсэн билээ. “Дараа нь ... **төгсгөл** ирнэ... **Эцэст нь** хүчингүй болох дайсан бол үхэл мөн... Энэ нь Бурхан **бүгдэд бүх юм** болохын тулд юм” (1 Коринт 15:24-28).



Ургац заавал үхлээр эхлэх жамтай. **“Хэрэв улаан буудайн үр газар унаад үхэхгүй бол тэр ганцаараа үлдэнэ. Харин хэрвээ тэр үхвэл олон үр бий болгоно”** (Иохан 12:24). Энэ үгийг Есүс үхлийнхээ тухай ярьсан билээ. Тэрээр “олон үр” гаргахыг зорьжээ. Гэтэл үхэшгүй амьтай Шинэ бүтээл бий болохын тулд хуучин бүтээл заавал үхэх ёстой. Үхэшгүй амьдралд хүрэх Ертөнцийн Эзэний зам үхлийн хөндийгөөр дамжин хөтөлдөг билээ (Дуулал 23:4). Гэтэл энэ зам “олон үр” бий болоход хүрнэ. Есүс энэ хэцүү, ганцаардмал замаар явсан учраас ганцаараа үлдэхгүй, арвин их ургацаа заавал хураах болно.



Амьд болгогдохыг Паул ч гэсэн тарьсан үр ургахтай зүйрлэдэг. Үр бол үзэмж муутай, хүч багатай, өчүүхэн, “нүцгэн” бөгөөд хөрсөнд суулгахаар задран үхэх тавилантай. “Тарьдаг нь үхэхгүй бол амилахгүй...” (1 Коринт 15:36). Тэгээд тогтсон цаг нь ирэхээр тарьсан нь ургаж, цоо шинэ хэлбэрээр газраас гарч ирнэ.<sup>4</sup>

4 Дахин амилахын энэ үлгэр загварыг Библийн дагуухь оршуулга харуулахын тулд нас барсан хүний шарилыг шатаадаггүй, бас хээр талын ан амьтанд идүүлэхгүй, газрын хөрсөнд оршуулдаг. Ингээд шарилыг нь нэг ёсондоо “тарьж” үйлээрээ дахин амилахыг нь зөгнөн зарладаг юм.



Тухайн үрээс ургах ургамал, хөөрхөн цэцэг ч бай, сүрлэг мод ч бай үрнээсээ эрс өөр, гоёмсог, сүр жавхаатай байдаг. Энэ гайхамшигтай хувирал чухам яаж явагдахыг хэн ч хэлж мэдэхгүй, ямар ч шинжлэх ухаантан тайлбарлаж чадахгүй. Хүний нас барсан бие махбод хөрсөнд яг л үр шиг “таригддаг” бөгөөд хожим түүнээс “ургах” бие нь одоогийн биетэй зүйрлэшгүй сүр жавхлантай сайхан байх болно (1 Коринт 15:35-38). Эцсийн ургац хураагдах үед “Үхэл ялалтад залгигдсан” гэдэг үг бүрмөсөн биелэх болно (Исаиа 25:8, 1 Коринт 15:54).


Есүс бидэнд хэлэхдээ, “Бүү ай. Би бол эхэн ба эцэс бөгөөд амьд Нэгэн мөн. Би үхсэн байсан. Харагтун, Би үеийн үед амьд байна. **Надад үхэл ба Үхэгсдийн орны түлхүүр бий**” (Илчлэлт 1:17-18). Үнэхээр “тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг” Түүнд өгсөн билээ (Матай 28:18). Үхлийн хүчээс гаргах түлхүүр одоо Есүсийн гарт орсон. Тогтсон цаг ирэхээр Христ үхэгсдийн орны цоожийг нээж, бүгдэд дараалынх нь дагуу үхэшгүй амь хайрлах болно.





Есүс дахин амилж шинэ хүн төрөлхтөнийг эхлүүлсэн нь түүхэн дэх хамгийн чухал үйл явдал мөн. Учир нь “Хэрэв Христ амилуулагдаагүй бол та нарын итгэл хоосон агаад та нар ч нүгэлдээ байсаар байна...

Хэрэв бид зөвхөн энэ амьдралынхаа төлөө Христэд найдсан бол бид нар бүх хүмүүсээс хамгийн өрөвдөлтэй нь болно. Харин чухамдаа *Христ үхэгсдээс амилуулагдсан бөгөөд нойрсогсдын анхны үр жимс мөн*. Учир нь үхэл нэг хүнээр ирсэн тул үхэгсдийн амилал мөн нэг хүнээр иржээ. Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно. Харин тус бүр өөрийн дараалалтай байна...” (1 Коринт 15:17-22).



Итгэгч бидний үүрэг бол Түүний үгийг хүлээн аван итгэхэд л орших билээ. □



### Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Barnes, A. (1870). *Albert Barnes' Notes on the Bible*. As found in the [MySword Bible study software program](#)

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Lenard, J. (2018). *Mysteries of Jesus' Life Revealed—His Birth, Death, Resurrection, and Ascensions*. Accessed on Dec 9<sup>th</sup>, 2023 at <https://truthinscripture.net/2017/02/19/jesus-death-and-resurrection-timing-of-the-spring-feasts/>

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). *Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons)*. [www.blueletterbible.org](http://www.blueletterbible.org)